



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 11 өдөр

Дугаар Д/627

Хэрлэн сум

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний 2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гутлын үйлдвэрийн 283,171,160 төгрөгийн балансын үнэтэй, 72,442,216 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 210,528,944 төгрөгийн үлдэх өртөгтэй барилга, тоног төхөөрөмжийг 15 хувиар, газрыг 17,172,000 төгрөгөөр, Хэрлэнбаян-Улаан тосгоны захирагчийн ажлын албаны 12,000,000 төгрөгийн балансын үнэтэй, 12,000,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй Kia trade автомашин, Бэрх хотын Захирагчийн ажлын албаны 16,488,000 төгрөгийн балансын үнэтэй 16,488,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй Istana автомашин, Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын 40,000,000 төгрөгийн балансын үнэтэй 18,000,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 22,000,000 төгрөгийн үлдэх өртөгтэй Ковш зэргийг 50 хувиар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 42,000,000 төгрөгийн балансын үнэтэй 42,000,000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй Teana автомашиныг 40 хувиар тус тус үнэ бууруулж худалдахыг хавсралтаар баталсугай.

2. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч: Б.Должинсүрэн

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Тэмдэглэл

хөтлөгч: Л.Отгончимэг

Орон нутгийн өмчийн газрын хуулийн  
зөвлөх

D:\My Documents\ Захирамж-2023

231011470

2.

3.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 тоот өрөөнд зохион байгуулсугай.


4.Эд хөрөнгийн дуудлага худалдаа хийх ажлыг хууль тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

ҮНЭ БУУРУУЛАН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ



д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалт танд орсон огноо	Балансын үнэ	хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Худалдах үнийн санал		
							Анхны санал	Бууруулах санал	АИТХ-ын шийдвэр
1	Хэнтий-Ус ХХК Гутлын үйлдвэр	/Барилга, тоног төхөөрөмж/	2012	283,171,160	72,442,216	210,528,944	210,528,944	178,950,000.00	178,950,000
2	Хэнтий-Ус ХХК Гутлын үйлдвэр	Гутлын үйлдвэрийн газар	2012	17,172,000	0	17,172,000	17,172,000	17,172,000	17,172,000
3	Харлэнбаян-Улаан тосгон	Шатахуун тээвэрлэх машин /Киа траде/ 66-72ХЭУ	1995	12,000,000	12,000,000	0	2,000,000	1,000,000	1,000,000
4	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	Теопа автомашин	2012	42,000,000	42,000,000	0	5,000,000	3,000,000	3,000,000
5	Норовлин сумын Засаг даргын Тамгын газар	Ковш	2018	40,000,000	18,000,000	22,000,000	22,000,000	11,000,000	11,000,000
6	Бэрх хотын захирагчийн ажлын алба	Истана 15-71 ХЭУ	2014	16,488,000	16,488,000	0	2,500,000	1,250,000	1,250,000
<b>Нийт дүн</b>				<b>410,831,160</b>	<b>160,930,216</b>	<b>249,700,944</b>			